

ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ҮНИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН МЭДЭЭЛЭЛ


/2015 оны 4 сарын 29-ны өдрийн байдлаар/

МАХНЫ ҮНЭ


2015 оны 04 сарын 29-ны өдрийн байдлаар Баруун сайхан, Зүүн сайхан, Хан-уул, худалдааны төвд байрлалтай мах, ногооны захын ханшаар хонины 1 кг мах дунджаар 7500 төгрөгөөр, ямааны мах 6900, адууны мах 6800 төгрөгөөр тус тус худалдаалагдаж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хонины махны үнэ 500 төгрөгөөр, адууны мах 300 төгрөгөөр, ямааны махны үнэ 900 төгрөгөөр тус тус буурчээ. Харин өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад хонь, ямаа, адууны махны үнэ 33-234 төгрөгөөр тус тус өссөн байна.

Зураг1.Махны үнэ 2015 оны 4 сар

Хонины махны үнэ, 1 кг, төгрөгөөр



Адууны махны үнэ, 1 кг, төгрөгөөр




Ямааны махны үнэ, 1 кг, төгрөгөөр



ГУРИЛ, БУДАА, СҮҮ, ЭЛСЭН ЧИХРИЙН ҮНЭ

2015 оны 4-р сарын 29-ны өдрийн байдлаар малын шингэн сүү худалдаанд зарагдахгүй байна. Харин цагаан будааны үнэ дунджаар 2000 төгрөг, элсэн чихрийн үнэ дунджаар 2000 төгрөг, алтан тариа 1-р гурил 1133 төгрөгөөр худалдаалагдаж байгааг өмнөх оны мөн үетэй харьцуулахад алтан тариан гурил 13.3 хувиар, элсэн чихрийн үнэ 4.0 хувиар өсч, харин цагаан будааны үнэ 10.0 хувиар буурсан байна. Харин өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад тогтвортой байна.


Зураг 2. Цагаан будаа, элсэн чихэр, гурилын үнэ, 2015 оны 4 сар, төгрөгөөр



АВТОБЕНЗИН, ДИЗЕЛИЙН ТҮЛШНИЙ ҮНЭ

2015 оны 04-р сарын 29-ны өдрийн байдлаар Даланзадгад суманд үйл ажиллагаа явуулж байгаа Шатахуун түгээх газруудын мэдээгээр бензин А-80 дунджаар 1650 төгрөг, бензин АИ-92 дунджаар 1890 төгрөг, дизелийн түлш дунджаар 1910 төгрөгийн үнэтэй худалдаалагдаж байгаа нь өмнөх долоо хоногийнхтой харьцуулахад тогтвортой байна.


Зураг 3. Авто бензин, дизелийн түлшний үнэ, 2015 он 4 сар, төгрөгөөр



ЯМААНЫ НООЛУУРЫН ҮНЭ

2015 оны 04-р сарын 29-ны өдрийн байдлаар Даланзадгад суманд үйл ажиллагаа явуулж буй түүхий эдийн захад ямааны цагаан ноолуур дунджаар 47000 төгрөгийн үнэтэй худалдаалагдаж байгаа нь өмнөх долоо хоногийнхтой харьцуулахад 6.0 хувиар буурсан байна.

Зураг 4. Ямааны ноолуурын үнэ, 2015 он 4 сар, төгрөгөөр



Өмнөговь аймгийн Статистикийн хэлтэс.